



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 10 өдөр

Дугаар: 8/499

Арвайхээр сум

Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны  
өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн “Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээ”-ний тухай 279 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах, шалгах, хүлээн авах ажлын хэсгийг 1 дүгээр, өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг 2 дугаар, аймаг, сумдын аюулгүйн нөөцөд бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн хэмжээг 3 дугаар, малчдын түвшинд бэлтгэх өвс, гар тэжээл, хужир шүүний хэмжээг 4 дүгээр, аймгийн төвийн хүн амын 2024 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан бэлтгэх махны хэмжээг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймаг сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг тухай бүрд нь шийдвэрлэж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идерсайхан), аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Д.Одонбаяр), аймгийн төвийн хүн амын 2024 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээний махны нөөцийг бүрдүүлэн ажиллахыг Арвайхээр сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч (Б.Ганбат) нарт тус үүрэг болгосугай.

2. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг төлөвлөгөөний дагуу сайтар зохион байгуулж, биелэлтийн явц, үр дунг 2023 оны 10 дугаар сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ОРЛОГЧ

И.ДОРЖСҮРЭН



6223 11 1002

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар  
сарын 10-ны өдрийн 11 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт

ХӨДӨӨ АЖ АХҮЙН САЛБАРЫН 2022-2023 ОНЫ ӨВӨЛЖИЛТ,  
ХАВАРЖИЛТЫН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ, ШАЛГАХ,  
ХҮЛЭЭН АВАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:  
Ц.Идэрсайхан (аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга)

А.Нямдаваа (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын  
хүрээний агентлаг Мал эмнэлгийн газрын дарга)

Д.Одонбаяр (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын  
хүрээний агентлаг Онцгой байдлын газрын дарга)

Д.Шивааннүрдэв (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын  
хүрээний агентлаг Эрүүл мэндийн газрын дарга)

Ч.Чанцалдиймаа (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын  
хүрээний агентлаг Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн  
дарга)

Д.Лхам-Оролмаа (“ӨВ-А33А” ТӨХК-ийн захирал)

Сумын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: С.Цэдэнбалжир (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын  
хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

-оо-

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар  
сарын 10-ны өдрийн 09 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт

**ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН 2023-2024 ОНЫ ӨВӨЛЖИЛТ, ХАВАРЖИЛТЫН БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хийгдэх ажил	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцсан албан тушаалтан, газар агентлаг	Хамтрах газар
<b>Нэг. Хүнс, хөдөө аж ахуйн газар</b>				
1.1	Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах талаар нарийвчилсан төлөвлөгөө батлуулж, биелэлтэд хяналт тавих	8 сард	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын Тамгын газар
1.2	Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн "Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" 279 дүгээр тогтоолын хавсралтын дагуу аймгийн нөөцөд 150 тн өвс, 50 тн тэжээл, сумдын аюулгүйн нөөцөд 950 тн өвс, 760 тн тэжээлийг тус тус бэлтгэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тооцох	8-11 сард	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын Тамгын газар
1.3	Аймгийн хэмжээнд 2023-2024 онд өвөлжих болон хэрэгцээлэх малын төрлийг сүргийн зохистой харьцаанд тулгуурлан аймаг, сумын хэмжээнд тоог нэгтгэн боломжит хэмжээгээр эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах, бүх хэлбэрээр дэмжиж, хяналт тавьж ажиллах, тооцоо гаргах	8-10 сард	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын Тамгын газар
1.4	Аймаг, сумын хэмжээнд орон нутгийн болон аймаг дундын улсын тусгай хэрэгцээний отрын нөөц нутагт өвөлжүүлж, хаваржуулах мал, малчин өрхийн судалгааг гаргаж, ажлыг зохион байгуулах	8-11 сард	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын Тамгын газар
1.5	Малчдын түвшинд өвс, гар тэжээл, хужир шүүг бэлтгэх тоо хэмжээнд хяналт тавьж, аймгийн аж ахуйн нэгж иргэдийн тариалсан ногоон тэжээл, үр тариа, байгалийн хадланг орон нутагтаа нөөц бүрдүүлэх болон худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, өвс хадлан бэлтгэх гадны аймаг сүм, аж ахуйн нэгж, иргэдтэй гэрээ байгуулан, чанартай, хямд үнээр өвс бэлтгэн нийлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах.	8-12 сард	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын Тамгын газар

1.6	Говийн сумдаас хужир шүү бэлтгэн хангайн сумдад өвс, ногоон тэжээлээр солилцоо худалдаа буюу бартердах ажлыг зохион байгуулах	9-12 дугаар сард	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын Тамгын газар
1.7	Улсын төсвийн болон төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр шинээр гаргаж байгаа инженерийн хийцтэй гүн өрмийн худгийн ажлын чанар, гүйцэтгэлд хяналт хийж, ажлыг хугацаанд нь технологийн дагуу гүйцэтгүүлэн 11 дүгээр сарын 15-ны дотор ашиглалтад оруулан, сум орон нутагт хүлээлгэн өгөх.	8-11 сард	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын Тамгын газар Гүйцэтгэгч аж ахуйн нэгж
1.8	Хээлтүүлэгч малын судалгааг гаргаж, дутагдалтай байгаа хээлтүүлэгчийг тохиромжтой бүс нутгаас олж нийлүүлэх, худалдан борлуулах, цаг хүндэрх төлөвтэй бүс нутагт хээлтэгчийг өнжөөх ажлыг зохион байгуулах, хуваарь гаргах	8-12 сард	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын Тамгын газар
1.9	Нийт мал сүрэгт үзлэг ангилалтын ажлыг технологийн дагуу хийж, шаардлага хангахгүй үржлийн малын 10 хүртэлх, дундаас доош тарга хүчтэй, эр сувай малын 50 хүртэлх хувийг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах, хуваарь гаргах	8-12 сард	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын Тамгын газар
1.10	Аймгийн хэмжээнд хүн амыг чанарын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр тогтвортой, хүртээмжтэй хангахад шаардагдах махны нөөцийг бүрдүүлэх, нөөцийн махны чанарт анхаарах, малчдын мал махаа борлуулах зах зээлийг бий болгох талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	8-12 сард	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын Тамгын газар
1.11	Ургацын урьдчилсан балансыг гаргаж, ургамлын өвчин хортеноос хамгаалах, урьдчилан сэргийлэх, ургац хураалтын үед баримтлах технологийн зөвлөмжөөр хангаж, ургац хураалтын мэдээг бүрэн авч мэдээлэх, төмс, хүнсний ногооны зоорийн тоог нэмэгдүүлэх, хуучин ашиглалтад байгаа зоориудыг засварлах, ариутгалд хамруулж, зоорины бэлэн байдлыг хангах, бүтээгдэхүүний хадгалалтад хяналт тавих, явцыг газар дээр нь үзэх	8-9 сард	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын Тамгын газар
1.12	Газар тариалангийн мэдээллийн нэгдсэн санд холбогдох мэдээллийг оруулж, цахим системийг нэвтрүүлж, гарал үүслийн гэрчилгээг цахимаар олгох	8-9 сард	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын Тамгын газар
1.13	Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний ургацыг бүрэн авах, төмс хүнсний ногооны борлуулалтын цэг ажиллахад дэмжлэг үзүүлэх, ургац хураалтад ажиллах хүн хүчний судалгааг гаргаж, хүн хүч нэмэгдлээр ажиллуулах ажлыг зохин байгуулах	8-9 сард	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын Тамгын газар
1.14	Ургацыг малаас хамгаалах, ургац хураалтын ажил дусах хүртэл тариалангийн талбайн ойр орчимд малчин, мал бүхий этгээдийг суурьшуулалгүй байх, малыг байнгын хариулгатай байлгах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.	8-11 сард	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын Тамгын газар

1.15	Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг сүм, багууд хэрхэн зохион байгуулж байгаад хяналт тавих, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг шуурхай танилцуулах, эрчимжүүлэх, мэдээллийг дамжуулах.	8-12 сард	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Аймгийн Засаг даргын Тамгын газар
1.16	Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх, орлого бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих	8-12 сард	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Аймгийн Засаг даргын Тамгын газар

#### Хоёр. Мал эмнэлгийн газар

2.1	Мал сүргийг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулж аймаг, сүм дамжсан отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих;	8 сараас ирэх оны 4 сар хүртэл	Мал эмнэлэгийн газар	Сумдын Засаг даргын Тамгын газар, Мал эмнэлэг үржлийн нэгж
2.2	Малын гоц халдварт, халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулах, хянах, үр дүнг тайлагнах;	8 сараас ирэх оны 7 сар хүртэл	Мал эмнэлэгийн газар	Сумдын Засаг даргын Тамгын газар, Мал эмнэлэг үржлийн нэгж
2.3	Малын гоц халдварт өвчний голомт бүхий сүм болон тухайн бүс нутагт хорио цээрийн дэглэм тогтоож, өвчний дэгдэлтийг бууруулах, тэмцэх арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх	8 сараас ирэх оны 7 сар хүртэл	Мал эмнэлэгийн газар	Сумдын Засаг даргын Тамгын газар, Мал эмнэлэг үржлийн нэгж
2.4	Мал сүргийг угаалга, туулгалтад бүрэн хамруулах, сэг зэмийн устгал, халдвартгүйгэлийн ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулж гүйцэтгэлд нь хяналт тавих;	8 сараас ирэх оны 7 сар хүртэл	Мал эмнэлэгийн газар	Сумдын Засаг даргын Тамгын газар, Мал эмнэлэг үржлийн нэгж

#### Гурав. Ус цаг уур, орчны шинжилгээний төв

3.1	Байгаль цаг уурын аюулт үзэгдэл /уер, усны аюул, хүчтэй салхи, шороон болон цасан шуурга г.м/-ээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг холбогдох байгууллага, сүм, баг, малчид, ард иргэдэд байнга хүргэж байх, сэрэмжлүүлэг, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байх	Тухай бүр	Ус цаг уур орчны шинжилгээний төв	Сумдын Засаг даргын Тамгын газар
-----	--	-----------	-----------------------------------	----------------------------------

3.2	Aймгийн намаржилт, өвөлжилтийн зураглал, өвөл хаврын бэлчээрийн даац, төлөв байдал, хур тунадасны урьдчилсан болон тухайн үеийн мэдээллийг гарган холбогдох байгууллагуудад шуурхай танилцуулж ажиллах, урт дунд хугацааны урьдчилан сэргийлэх мэдээг боловсруулж олон нийтэд хүргэх	Тухай бүр	Ус цаг уур орчинь шинжилгээний төв	Сумдын Засаг даргын Тамгын газар
<b>Дерөв. Онцгой байдлын газар</b>				
4.1	Улсын нөөцийн салбар цэгүүдээс нөөцийн өвс тэжээл татан авалт, хадгалалтын технологийг мөрдөх, чанарын шаардлага хангахгүй өвс, тэжээлийг устгалд оруулж цэвэрлэх, малчид иргэдэд худалдан борлуулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах	Тухай бүр	Онцгой байдлын газар	Хүнс, хөдөө аж ахуйн газар
4.2	Цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг хууль тогтоомж, батлагдсан төлөвлөгөөний дагуу шуурхай зохион байгуулж ажиллах	Тухай бүр	Онцгой байдлын газар	Холбогдох агентлагууд
4.3	Холбогдох сумдад малын гоц халдварт шүлхий, мянган өвчиний өвчтөнжүүлалт хийгдэж дуусталх хугацаанд хорио цээр тогтоох болон цаашид малчдын отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнд хатуу хяналт тавих, сэжигтэй мал, амьтныг нэвтрүүлэхгүй байх арга хэмжээг зохих журмын дагуу удирдан чиглүүлэх, хяналт тавьж ажиллах	Тухай бүр	Онцгой байдлын газар	Холбогдох агентлагууд
4.4	Гангийн болон эрсдэлийн, шаардлагатай тохиолдолд өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдлын үнэлгээ хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллах	Тухай бүр	Онцгой байдлын газар	Холбогдох агентлагууд
<b>Тав. Эрүүл мэндийн газар</b>				
5.1	Отор нүүдлээр явж байгаа малчин өрхийн жирэмсэн эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 0-5 насны хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө гаргах ажиллах	Тухай бүр	Эрүүл мэндийн газар	Хүнс, хөдөө аж ахуйн газар
<b>Зургаа. Сумын Засаг дарга нар</b>				
6.1	Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах талаар нарийвчилсан төлөвлөгөө гарган ажиллаж, хэрэгжилтийг хангуулах, биелэлтэд хяналт тавих, шаардлагатай арга хэмжээг авах.	8-11 сард	Сумын Засаг дарга	Багийн Засаг дарга
6.2	Энэ захирамжийн хавсралтаар батлагдсан сумын болон малчдын түвшинд бэлтгэх өвс, тэжээлийг чанартай, заасан хэмжээнд бүрдүүлэх	8-11 сард	Сумын Засаг дарга	Багийн Засаг дарга

6.3	Улсын тусгай хамгаалалттай газар болон хилийн зурvas газарт отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, малын тооны судалгааг урьдчилан гаргаж, холбогдох төрийн байгууллагуудаас зөвшөөрөл авч гэрээний дагуу отроор өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулах	8-11 сард	Сумын Засаг дарга	Багийн Засаг дарга
6.4	Өөр аймаг, сумын нутагт оторлож байгаа малчин өрхийг тухайн орон нутгийн захиргааны байгууллага болон хүн, мал эмнэлгийн байгууллагад бүртгүүлэх, холбогдох мэргэжлийн байгууллагын тусламж үйлчилгээ үзүүлж ажиллах	Тухай бүр	Сумын Засаг дарга	Багийн Засаг дарга
6.5	Бэлчээрийн ургамлын гарц, байдлыг газар дээр нь үзэж, даац багтаамж, бэлчээрийн ургац, намаржилтын байдлыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээр, сум дундын отрын бүс нутгийг хамгаалалтад авах, малын хөлөөс чөлөөлөх арга хэмжээ авах	8-12 сард	Сумын Засаг дарга	Багийн Засаг дарга
6.6	Газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хадгалж, мэдээ мэдээлэл, мэргэжил арга зүйгээр хангаж, ургамал хамгааллын арга хэмжээ, ургац хураалтад дэмжлэг үзүүлэх, урамшуулалд хамруулах	8-11 сард	Сумын Засаг дарга	Багийн Засаг дарга
6.7	Малын гоц халдварт шүлхий, боёг малын мялзан өвчиний вакцинуулалт хийгдэж дуусталх хугацаанд болон цаашид малчдын отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнд хатуу хяналт тавих, сэжигтэй мал, амьтныг нэвтрүүлэхгүй байх арга хэмжээг сум орон нутгийн тувшинд хэрэгжүүлэх.	Тухай бүр	Сумын Засаг дарга	Багийн Засаг дарга МЭҮНэгж
6.8	Малын гоц халдварт өвчиний халдварт бүртгэгдсэн сумдууд тухайн бүс нутагтаа хороо цээрийн дэглэм тогтоож, өвчиний дэгдэлтийг бууруулах, зогсоо арга хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	Тухай бүр	Сумын Засаг дарга	Багийн Засаг дарга МЭҮНэгж
6.9	Малчин өрх бүрд өвөлжилт, хаваржилтын бэлтгэлээ хангах чиглэлээр заавар зөвлөмж өгөх, үүрэн холбооны тархалтыг сайжруулах, өрх бүрд цаг агаарын мэдээ хүргэх, цаг үеийн мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх	Тухай бүр	Сумын Засаг дарга	Багийн Засаг дарга
<b>Долоо. Малчид, мал бүхий иргэд</b>				
7.1	Мал сүрэгтээ тарга хүч авхуулах, малын чанар, сүргийн бүтцийн зохист харьцаанд тулгуурлан малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ангилан ялгах, хүнсэнд хэрэглэх зэрэг арга хэмжээнүүдийг эртнээс төлөвлөн хэрэгжүүлэх	Тухай бүр	Малчид	Багийн Засаг дарга
7.2	Мал өвөлжүүлэх, хаваржуулах бэлтгэлийг сайтар хангах, байгалийн давагдашгүй хүчин зүйл, гэнэтийн нэхцэл байдлын үед мал сүргээ хамгаалах, хариулга маллагаанд байлгаж бага насны хүүхдийг малд явуулахгүй байх цаг агаарын мэдээ мэдээллийг тогтмол авч учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх	Тухай бүр	Малчид	Багийн Засаг дарга

7.3	Мал сүргээ малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариулга маллагаа хяналтыг сайжруулж, мэргэжлийн байгууллагын заавар зөвлөгөөг сайтар дагаж мөрдөх	тухай бүр	Малчид	Багийн Засаг дарга
7.4	Өөрсдийн мэдэлд байгаа хуц, ухныг тодорхой нөхцөлөөр мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид гэрээ түрээсийн хэлбэрээр шилжүүлэх чиглэлийг барих, байгаль цаг уурын нөхцөл, бэлчээрийн гарц, малын тарга хүчээс хамааруулан хээлтэгч малыг өнжөөж төллүүлэх, дутагдаж буй хээлтүүлэгчийг мэргэжлийн байгууллага, мэргэжилтний зөвшөөрөлгүй гоц халдварт өвчний голомт бүхий бус нутаг, гадны аймгаас худалдан авч, малын шилжилт хөдөлгөөн хийхгүй байх,	тухай бүр	Малчид	Багийн Засаг дарга
7.5	Мал өвөлжүүлэх хашаа хорооны хөрзөнг ховхолж, малын хэвтэр бууцыг сайн хатаах, хуурай бууцыг хангалттай хэмжээгээр нөөцлөн бэлтгэх, хороо бууц, худаг уст цэгийн засвар тохижилт, ариутгал халдвартгүйтгэлийн ажлыг чанартай хийж гүйцэтгэх, худгийн тагийг сайтар дулаалж хөлдөхөөс хамгаалах	тухай бүр	Малчид	Багийн Засаг дарга
7.6	Малчин өрх бүр хонин толгойд шилжүүлсэн нэг мал тутамд өвс 3кг, гар тэжээл 1кг, эрдэс тэжээл, хужир шүү 2кг-аар тооцож бэлтгэж, нөөцлөх	тухай бүр	Малчид	Багийн Засаг дарга
7.7	Өөр аймаг, сумын нутагт оторлож байгаа малчин өрхүүд аль аймаг, сумын нутагт оторлож байгаа мэдээллээ сум орон нутгийн удирдлагууддаа өгч байх	тухай бүр	Малчид	Багийн Засаг дарга
7.8	Малчид өөрсдийн хувийн бэлтгэлээ сайтар хангаж, холбоо барих утас, станцтай байх, дулаан хувцас, хоол хүнс, ус тулш, хүн, малын эмийн сан, хүрз, жоотуу зэрэг багаж хэрэгслийг бэлэн байлгах, GPS-ийн ач холбогдлыг сурталчлах ажлыг зохион	тухай бүр	Малчид	Багийн Засаг дарга

-Оо-

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар  
сарын 10-ны өдрийн 11 дугаар  
захирамжийн 3 дугаар хавсралт

**АЙМАГ, СҮМЫН ХЭМЖЭЭНД БЭЛТГЭВЭЛ  
ЗОХИХ ӨВС, ТЭЖЭЭЛИЙН ХЭМЖЭЭ**

№	Сумын нэр	Нийт аймгийн хэмжээгээр бэлтгэвэл зохих (тн)	
		Өвс	Тэжээл
1	Баян-Өндөр	50	40
2	Бурд	50	40
3	Бат-Өлзий	50	40
4	Баруунбаян-Улаан	50	40
5	Баянгол	50	40
6	Гучин-Ус	50	40
7	Есөнзүйл	50	40
8	Өлзийт	50	40
9	Зүүнбаян-Улаан	50	40
10	Богд	50	40
11	Нарийнтээл	50	40
12	Сант	50	40
13	Тарагт	50	40
14	Төгрөг	50	40
15	Уянга	50	40
16	Хайрхандулаан	50	40
17	Хужирт	50	40
18	Хархорин	50	40
19	Арвайхээр	50	40
20	Аймгийн аюулгүйн нөөцөд /тн/ НИЙТ	150 1100	50 810

-оOo-

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар  
сарын 10-ны өдрийн 11:00 дугаар  
захирамжийн 4 дүгээр хавсралт

МАЛЧДЫН ТҮВШИНД БЭЛТГЭХ ӨВС, ГАР ТЭЖЭЭЛ,  
ХУЖИР, ШҮҮ БЭЛТГЭХ ХЭМЖЭЭ

д/д	Сумын нэр	Малчдын бэлтгэх тэжээл (тн)		
		Өвс	Гар тэжээл	Хужир, шүү
1	Баян-Өндөр	1860	620	1240
2	Бурд	1709	570	1139
3	Бат-Өлзий	2419	806	1613
4	Баруунбаян-Улаан	450	150	300
5	Баянгол	1568	523	1045
6	Гучин-Ус	552	184	368
7	Есөнзүйл	1058	353	705
8	Өлзийт	1067	356	712
9	Зүүнбаян-Улаан	1363	454	909
10	Богд	1092	364	728
11	Нарийнтээл	834	278	556
12	Сант	1058	353	705
13	Тарагт	1064	355	709
14	Төгрөг	648	216	432
15	Уянга	2263	754	1509
16	Хайрхандулаан	1073	358	715
17	Хужирт	1714	571	1143
18	Хархорин	1985	662	1323
19	Арвайхээр	1270	423	847
<b>ДҮН</b>		<b>25047</b>	<b>8349</b>	<b>16698</b>

-оОо-

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар  
сарын 10-ны өдрийн 11 дугаар  
захирамжийн 5 дугаар хавсралт

**АЙМГИЙН ТӨВИЙН ХҮН АМЫН 2024 ОНЫ ХАВРЫН УЛИРЛЫН  
ХҮНСНИЙ ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАН БЭЛТГЭХ МАХНЫ ХЭМЖЭЭ (ТН)**

№	Сумын нэр	Жишсэн хүн амын тоо	Нэг хоногийн хэрэгцээ (тн)	3 сарын хэрэгцээ, (тн)
1.	Арвайхээр	28,857	3.5	311.7
	Нийт	28,857	3.5	311.7

-оOo-